

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал .....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨӨ АЖ АХУЙН ХАЛХ ГОЛ  
ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН  
БҮСИЙН ЗАХИРГААНЫ ЗАХИРАЛ  
Д.БАТБОЛД ТАНАА

2020.02.27 № 06/62/  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн зөв, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих, нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Д.Батболд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналыг сайжруулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 05-аас 2020 оны 2 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Санхүүч-Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Санхүүч-Аудит” ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 01/24 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны үйл ажиллагааны эрхэм зорилго Дорнод аймгийн Халх гол сумын нутагт байрлах “Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүс” улсын хэрэгцээний газарт эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн аялал жуулчлалыг хөгжүүлэх, төрөөс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүний гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг бий болгон зах зээлийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл борлуулалтыг нэмэгдүүлэх, мал аж ахуй болон газар тариалангийн үйлдвэрлэл явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрчимжсэн мал аж ахуйг нэвтрүүлэх, газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж өртгийн сүлжээ бий болгох, мал аж ахуй, агро аялал жуулчлал, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах.
- Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид болон тус бүсэд үйл ажиллагаагаа явуулах иргэн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх.
- Гадаадын орнуудын болон дотоодын мал аж ахуй, газар тариалангийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан судалгаа хийх, судалгааны үндсэн дээр зорилтот хэрэглэгчидтэй экспорт, импортын худалдааны гэрээ байгуулах ажлыг зохион байгуулахад оролцох.
- Олон улсын зах зээлд Монголын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний брэндийг бий болгоход дэмжлэг үзүүлж ажиллах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.8.14 дэх заалт нэмсүгэй:... “23.8.14.газрын төлбөрийн 40 хувь.”, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.2 дахь заалтын “төлбөр” гэснийг “төлбөрийн 60 хувь” гэж өөрчилсүгэй.
- Газрын тухай хуулийн 15, 33 болон 34 дүгээр зүйлд нэмэлт, өөрчлөлт орсон.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 311,168.9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3,111.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 6,360.8 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь болгон авч үзсэнтэй холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 257,054.1 мянган төгрөгөөр буюу 10.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	169,119.8	164,201.6	(4,918.2)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	460,757.8	432,483.8	(28,274.0)
Үндсэн хөрөнгө	1,822,633.1	1,598,771.2	(223,861.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,452,510.7</b>	<b>2,195,456.6</b>	<b>(257,054.1)</b>
Өр төлбөр	164,201.6	165,701.9	1,500.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,288,309.1	2,029,754.7	(258,554.5)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,452,510.7</b>	<b>2,195,456.6</b>	<b>(257,054.1)</b>

Авлага дансны үлдэгдэл буурсан нь хувь хүний орлогын албан татварын авлага буурснаас шууд шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэл 164,201.6 мянган төгрөг нь 2016 онд өмнөх удирдлагын газар олгосон шийдвэрүүдийг Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 187 тоот тогтоолоор хүчингүй болгосонтой холбоотой үүссэн, шүүхэд нэхэмжлэх гаргасан аж ахуйн нэгжүүдэд өгөх өр төлбөртэй холбоотой Сангийн яамнаас авах авлага байна. Энэхүү авлагыг Шүүхийн шийдвэр эцсийн байдлаар гараагүй шалтгааны улмаас нэр бүхий аж ахуйн нэгжүүдэд өгч барагдуулах боломжгүй байна. Авлага

нь шүүхийн эцсийн шийдвэр гарсны дараа аж ахуйн нэгжид буцаан өгснөөр шийдвэрлэгдэхээр байна.

Тусгай зориулалттай бараа материалд бүртгэгдсэн 27,457.5 мянган төгрөгийн өртөг бүхий “Чиргүүлийн жатка”-г Тариалан эрхлэлтийг дэмжих сан руу 2019 оны 12 дугаар сарын 31-ээр шилжүүлсэн ба энэ нь бараа материалын дансны үлдэгдэл буурахад голлон нөлөөлжээ. Мөн бараа материалын дансны үлдэгдэл тайлант онд 6,900.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 2,907.4 мянган төгрөгөөр хорогдсон 54,132.6 мянган төгрөгийн мал байна. Тайлант оны төл мал болох 23 толгой тугалыг Дорнод аймгийн Халх гол сумын статистик мэдээлэл үндэслэн нэг тугалыг 300.0 мянган төгрөгөөр тооцон, нийт 6,900.0 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант үеийн элэгдэл байгуулснаас шууд шалтгаалжээ. Тайлант хугацаанд байгуулсан элэгдэл, хорогдлын зардал 225,591.9 мянган төгрөг байна. Тайлант хугацаанд 230.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил /дугуй ширээ/, худалдан авсан байна.

Биет бус хөрөнгө өссөн нь 1,500.0 мянган төгрөгөөр цахим системд суурилсан санхүүгийн программ хангамж худалдан авснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь Хувь хүний орлогын албан татварын өр төлбөрөөс шууд шалтгаалжээ.

Өр төлбөрийн үлдэгдэл 164,201.6 мянган төгрөг нь газар олгосон шийдвэрүүдийг Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 187 тоот тогтоолоор хүчингүй болгосонтой холбоотой 2016 онд үүссэн, нэр бүхий аж ахуйн нэгжүүдэд өгөх өр төлбөр юм.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,029,754.7 мянган төгрөг болж 258,554.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шууд шалтгаалжээ. Тайлант оны үйл ажиллагааны үр дүн алдагдалтай гарахад үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал шууд нөлөөлсөн байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн урсгал зардалд 400,990.5 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ. Нийт зардлын 400,990.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 395,895.0 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь дотоод томилолтын зардал, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлын хэмнэлтээс шалтгаалсан байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 14,760.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 13,026.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,734.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.



1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийг 388,105.5 мянган төгрөг гэж 12,885.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн нь Төсвийн тухай хуулийн 22.6.7 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Аудитын явцад залруулав.

Аудитаар илэрсэн 1,734.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

**2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Бараа материалын дансанд 54,132.6 мянган төгрөгийн 113 толгой мал бүртгэлтэй байна. Иймд дараагийн аудитаар малын бүртгэл, тайлагналтай холбоотой асуудлыг авч үзэх шаардлагатай гэж үзэж байна.

**2.12. Шилэн дансны мэдээлэл**

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагаас баталсан төсөв, гүйцэтгэлийн мэдээллийг хугацаанд нь байршуулсан, Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын мэдээллийг байршуулаагүй байна.

**2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлснээс зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилт 100 хувьтай байна.

**2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 1,734.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 6,360.8 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

**“Зөрчилгүй” дүгнэлт**

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

## Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3.1 *Балансын данстай холбоотой асуудал*

3.1.1 *Илрүүлэлт:* Улсын Их Хурлын 2016 оны 46 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулахаар шийдвэрлэсэн байна. Засгийн газрын 2016 оны 328 дугаар тогтоолоор бүсийн захиргааг байгуулан 500.0 мянган га газрыг “Улсын тусгай хэрэгцээнд” авч хилийн заагийг тогтоожээ. Гэвч дараах хүчин зүйлээс шалтгаалан бүсийн тусгай хэрэгцээний газрыг аж ахуйн эргэлтэд оруулах, үндэсний бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх ажил удааширсан байна.

1. Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирлын 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдөр “Гэрээ байгуулах тухай” А-01 тоот тушаал гаргаж, Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн тусгай хэрэгцээний газрын 63.5 хувь буюу 317.7 мянган га газрыг хууль зөрчин сонгон шалгаруулалтгүйгээр голчлон газар тариалангийн зориулалтаар 24 аж ахуйн нэгжид олгосон байна.
2. Хөдөө аж ахуй Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирлын 2017 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр “Тушаал хүчингүй болгох тухай” А-01 тоот тушаалыг гаргаж өмнөх удирдлагын шийдвэрийг цуцалсан. Аж ахуйн нэгжүүдээс газрын төлбөрт төлсөн төлбөрөөс 2016 онд 389,087.9 мянган төгрөг, 2017 онд 118,729.3 мянган төгрөгийн төлбөрийг тус тус буцаан төлж, 3 аж ахуйн нэгж 164,201.5 мянган төгрөгийг шүүхээр хэрэг эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл авахгүй гэж буцааж аваагүйгээс тус бүсийн захиргааны тайлан тэнцэлд өглөгөөр бүртгэлтэй байна.

Бүсийн захиргааны удирдлагаас 2016 оны 328 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан журмыг зөрчин 24 аж ахуйн нэгжид 317.7 мянган га газар олгосон тухай бүсийн захирлын 2016 оны А/01 дүгээр тушаалыг бүсийн захирлын 2017 оны А/01 тушаалаар хүчингүй болгосон. Энэ тушаалыг эс хүлээн зөвшөөрсөн 12 аж ахуйн нэгжийн төлөөлөл Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны

шүүхэд гомдол гаргаснаас 2019 оны байдлаар 2 аж ахуйн нэгж шүүхээс нэхэмжлэлээ буцаан авсан байна.

Эдгээр газрын маргаантай асуудлуудаас шалтгаалан Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, санхүүгийн тайланд тусгаагүй, дээрх өр төлбөрийг холбогдох аж ахуйн нэгжүүд нэхэмжлээгүй, авахаас татгалзсанаар санхүүгийн байдлын тайланд өр төлбөрөөр тусгагдсан.

- 3.1.2 Эрсдэл: Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийг байгуулж ажиллуулахтай холбогдон гарсан Улсын Их Хурлын 2016 оны 46, Засгийн газрын 2016 оны 328, 187, 2018 оны 109 дүгээр тогтоолуудыг хэрэгжүүлэхгүй хууль, тогтоомж зөрчигдөх. Байгууллагын холбогдох хууль, журамд заасан эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байх.
- 3.1.3 Өгсөн зөвлөмж: Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн улсын тусгай хэрэгцээний газрын тухай асуудал шүүхээр эцэслэн шийдвэрлэгдмэгц газрыг үнэлж санхүүгийн тайланд тусгах, аж ахуйн нэгжүүдэд өгөх өр төлбөрийг барагдуулж, тооцоог дуусгах.
- 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа нь 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 01/24 тоот албан бичгээр тайлбар ирүүлсэн.

### **3.2 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл**

- 3.2.1 Илрүүлэлт: Галлагаатай сууц бүхий ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт болон ажилтны мөнгөн урамшуулалд 1,400.0 мянган төгрөг зарцуулсан. Үүнээс нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй байна.
- 3.2.2 Эрсдэл: Нийгмийн даатгалын тухай хууль зөрчигдөх, цалин, шимтгэл, татварын тооцоололд алдаа гарах.
- 3.2.3 Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу дээрх орлогуудаас нийгмийн даатгалын шимтгэл нөхөн тооцох.
- 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж 2020 оны 2 дугаар сарын цалинд оруулж, шимтгэлийг нөхөн тооцох болно.

### **3.3 Зардлын данстай холбоотой асуудал**

- 3.3.1 Илрүүлэлт: Тайлант онд Хувь хүнд олгосон орлогоос 1,398.1 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутган авч төсөвт төлсөн ч Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутган тооцсон татварын тайлангийн төрлөөр бүртгүүлж, уг тайланг гаргаагүй байна. Ингэснээр татварын цахим системийн тооцооллоор 1,398.1 мянган төгрөгийн авлагатай байна.
- 3.3.2 Эрсдэл: Татварын ерөнхий хууль зөрчигдөх, татвар төлөгч үүргээ биелүүлэхгүй байх.
- 3.3.3 Өгсөн зөвлөмж: Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутган тооцсон татварын тайлангийн төрлөөр бүртгүүлж, уг тайланг нөхөж гаргах.
- 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж Татварын төрлөөр бүртгүүлж, уг тайланг нөхөн гаргах болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>629,877,588.95</u></b>	<b><u>596,685,378.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	169,119,772.49	164,201,606.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,586,595.06	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	165,533,177.43	164,201,606.00
3351	Байгууллагаас авах авлага	165,533,177.43	164,201,606.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	460,757,816.46	432,483,772.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	404,175,375.75	376,717,878.75
35110	Тусгай зориулалттай материал	404,175,375.75	376,717,878.75
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	6,442,440.00	1,633,300.00
35410	Бичиг хэргийн материал	2,042,440.00	1,063,300.00
35420	Аж ахуйн материал	400,000.00	570,000.00
35440	Түлш, шатах тослох материал	4,000,000.00	-
35600	Мал амьтад	50,140,000.71	54,132,593.25
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,822,633,117.25</u></b>	<b><u>1,598,771,246.16</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,822,633,117.25	1,598,771,246.16
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,822,633,117.25	1,597,271,246.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,400,754,673.00	2,400,754,673.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(852,502,675.13)	(985,897,764.07)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	193,670,407.00	193,670,407.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(103,279,151.13)	(126,940,942.41)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	479,482,139.12	479,482,139.12
39206	Хуримтлагдсан элэгдэл	(312,266,908.51)	(377,662,819.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,264,250.60	30,494,250.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,002,951.01)	(18,102,031.26)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,120,000.00	3,120,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(606,666.69)	(1,646,666.73)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-	1,500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	770,000.00	2,270,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(770,000.00)	(770,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,452,510,706.20</u></b>	<b><u>2,195,456,624.16</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>164,201,606.00</u></b>	<b><u>165,701,962.18</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	164,201,606.00	165,701,962.18
<b>413</b>	<b>Өглөг</b>	164,201,606.00	165,701,962.18
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,500,356.18
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	164,201,606.00	164,201,606.00
41361	Байгууллагад төлөх өглөг	164,201,606.00	164,201,606.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,288,309,100.20</u></b>	<b><u>2,029,754,661.98</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,288,309,100.20	2,029,754,661.98
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,288,309,100.20	2,029,754,661.98
51210	Өмнөх үеийн үр дүн	2,288,309,100.20	2,288,309,100.20
51220	Тайлант үеийн үр дүн	-	(258,554,438.22)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,452,510,706.20</u></b>	<b><u>2,195,456,624.16</u></b>

## 4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>838,918,648.79</b>	<b>407,890,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>435,619,548.79</b>	<b>6,900,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	435,619,548.79	6,900,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	435,569,548.79	6,900,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,331,571.43	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	434,237,977.36	6,900,000.00
120009	Бусад орлого	50,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>403,299,100.00</b>	<b>400,990,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	403,299,100.00	400,990,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	403,299,100.00	400,990,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>618,536,528.93</b>	<b>636,080,033.76</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>618,536,528.93</b>	<b>636,080,033.76</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	602,988,096.99	617,326,889.29
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	514,351.00	962,338.00
210301	Гэрэл, цахилгаан	514,351.00	962,338.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,210,210.00	25,716,200.00
210401	Бичиг хэрэг	4,105,610.00	5,256,640.00
210402	Тээвэр, шатахуун	13,127,200.00	16,661,900.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,977,400.00	3,797,660.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	8,878,550.00
210604	Урсгал засвар	-	8,878,550.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	26,585,885.00	21,071,050.00
210702	Дотоод албан томилолт	26,585,885.00	21,071,050.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	332,929,834.00	335,106,880.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	331,822,362.00	333,107,056.20
210803	Даатгалын үйлчилгээ	115,830.00	1,418,824.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	947,642.00	493,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	88,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	221,747,816.99	225,591,871.09
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	221,747,816.99	225,591,871.09
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	15,548,431.94	18,753,144.47
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,800,133.00	13,657,658.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,991,533.00	8,896,658.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,808,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	4,761,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,748,298.94	5,095,486.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,748,298.94	5,095,486.47
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>220,382,119.86</b>	<b>(228,189,533.76)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	(30,364,904.46)
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(30,364,904.46)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>220,382,119.86</b>	<b>258,554,438.22</b>

### 4.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>567,550,706.00</b>	<b>565,192,106.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>164,251,606.00</b>	<b>164,201,606.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	164,251,606.00	164,201,606.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	164,201,606.00	164,201,606.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	164,201,606.00	164,201,606.00
120009	Бусад орлого	50,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>403,299,100.00</b>	<b>400,990,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	403,299,100.00	400,990,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	403,299,100.00	400,990,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>567,550,706.00</b>	<b>563,462,106.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>567,550,706.00</b>	<b>563,462,106.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>387,800,668.06</b>	<b>380,507,355.53</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	514,351.00	962,338.00
210301	Гэрэл, цахилгаан	514,351.00	962,338.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,164,600.00	20,712,060.00
210401	Бичиг хэрэг	5,860,000.00	4,252,500.00
210402	Тээвэр, шатахуун	12,327,200.00	12,661,900.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,977,400.00	3,797,660.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	9,448,550.00
210604	Урсгал засвар	-	9,448,550.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	26,585,885.00	21,071,050.00
210702	Дотоод албан томилолт	26,585,885.00	21,071,050.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	338,535,832.06	328,313,357.53
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	337,428,360.06	326,313,533.53
210803	Даатгалын үйлчилгээ	115,830.00	1,418,824.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	947,642.00	493,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	88,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>179,750,037.94</b>	<b>182,954,750.47</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	13,800,133.00	13,657,658.00
213204	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	4,991,533.00	8,896,658.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	8,808,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	4,761,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	165,949,904.94	169,297,092.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	165,949,904.94	169,297,092.47
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-</b>	<b>1,730,000.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>-</b>	<b>1,730,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>1,730,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>1,730,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,730,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-</b>	<b>(1,730,000.00)</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

#### 4.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>			2,067,926,980.34	<b>2,067,926,980.34</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>2,067,926,980.34</b>	<b>2,067,926,980.34</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
C07	Тайлант үеийн үр дүн			220,382,119.86	<b>220,382,119.86</b>
D01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>2,288,309,100.20</b>	<b>2,288,309,100.20</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>2,288,309,100.20</b>	<b>2,288,309,100.20</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
D08	Тайлант үеийн үр дүн			(258,554,438.22)	<b>(258,554,438.22)</b>
D09	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>2,029,754,661.98</b>	<b>2,029,754,661.98</b>



#### 4.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	400,990,500.00	395,895,013.53	5,095,486.47	98.73
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	400,990,500.00	395,895,013.53	5,095,486.47	98.73
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	400,990,500.00	382,237,355.53	18,753,144.47	95.32
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	1,000,000.00	962,338.00	37,662.00	96.23
210301	Гэрэл, цахилгаан	1,000,000.00	962,338.00	37,662.00	96.23
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,070,400.00	20,712,060.00	358,340.00	98.30
210401	Бичиг хэрэг	4,431,100.00	4,252,500.00	178,600.00	95.97
210402	Тээвэр, шатахуун	12,661,900.00	12,661,900.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,977,400.00	3,797,660.00	179,740.00	95.48
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,409,000.00	9,448,550.00	(39,550.00)	100.42
210604	Урсгал засвар	9,409,000.00	9,448,550.00	(39,550.00)	100.42
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	22,947,300.00	21,071,050.00	1,876,250.00	91.82
210702	Дотоод албан томилолт	22,947,300.00	21,071,050.00	1,876,250.00	91.82
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	306,807,500.00	330,043,357.53	(23,235,857.53)	107.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	302,153,200.00	326,543,533.53	(24,390,333.53)	108.07
210803	Даатгалын үйлчилгээ	1,418,900.00	1,418,824.00	76.00	99.99
210804	Тээврийн хэрэгслийн татвар	493,000.00	493,000.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00	-	
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	16,442,500.00	13,657,658.00	2,784,842.00	83.06
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	16,442,500.00	13,657,658.00	2,784,842.00	83.06
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,442,500.00	8,896,658.00	2,545,842.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	4,761,000.00	239,000.00	95.22
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	400,990,500.00	395,895,013.53	5,095,486.47	98.73
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	400,990,500.00	395,895,013.53	5,095,486.47	98.73
131001	Улсын төсвөөс санхүүжих	400,990,500.00	395,895,013.53	5,095,486.47	98.73
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	22	21	1	95.45
620001	Удирдах ажилтан	6	5	1	83.33
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16	-	100.00

## 5. АУДИТЫН ЯВЦАД ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	<b>ХАА-н Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2019 оны санхүүгийн тайлангийн аудит</b>	Аудитын код:
<b>2019.12.31</b>			<b>САГ-2020/224/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>ХАА-н Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа</b>		/мянган төгрөгөөр/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
<b>А</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
1	Газартай холбоотой маргаан 2 жил гаруйн хугацаанд шийдэгдээгүй байсаар Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019.08.21-ний өдрийн 128/ШШ2019/0504 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019.12.024-ний өдрийн шийдвэрээр "Нексүс зоне" ХХК болон нэр бүхий 10 компанийн нэхэмжлэхийн шаардлагуудыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон. Шүүхийн шийдвэр эцэслэн гараагүйтэй холбоотой аж ахуйн нэгжүүдэд өгөх 164,201.6 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй, газрын үнэлж санхүүгийн тайланд тусгаагүй байна	-	Зөвлөмж өгөх	Захирал	Ж.Энхжаргал
2	Галлагаатай сууц бүхий ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт болон ажилтны мөнгөн урамшуулалд 1,400.0 мянган төгрөг зарцуулсан. Үүнээс нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй байна.	336.0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б.Оюунцэцэг
3	Хувь хүнд олгосон орлогоос 1,398.1 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутган авч төсөвт төлсөн ч Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутган тооцсон татварын тайлангийн төрлөөр бүртгүүлж, уг тайланг гаргаагүй.	1,398.1	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б.Оюунцэцэг
<b>Дүн</b>		<b>1,734.1</b>			



